

5. СОЁЛЫН ФИЛОСОФИ, СОЁЛ СУДЛАЛ

Соёлын динамикт холбогдох зарим асуудлууд

Доктор, профессор Т.Дорждагва

Гадаад, дотоодод хэвлэгдсэн соёл судлалын олон сурах бичиг, гарын авлагыг үзэж байхад соёлын оршихуйн тухай янз бүрийн тайлбарлалыг өгсөн байх бөгөөд соёлын динамиктай холбогдуулан динамик ба статик, дэвшил ба регресс (бууралт - Т.Д.), уламжлал ба шинэчлэл, хувьсал ба хувьсгал, хөгжил ба зогсонги байдал, шугаман дэвшлийн ба орчилт хөгжлийн онол, тогтвортой байдал ба хямрал гэх зэрэг олон асуудлыг хөндөж авч үзсэн нь харагдаж байна.

Тухайлбал, судлаач А.И.Кравченко 2003 онд Москва хотноо хэвлүүлсэн "Соёл судлал. Их, дээд сургуульд зориулсан гарын авлага" /5. 174-176/ гэсэн нэртэй бүтээлдээ эл асуудлаар зориуд тусгайлан тэмдэглэсэн олон тооны дүгнэлт хийсэнээс энд заримыг толилуулбал:

- Соёл хэзээ ч хөдөлгөөнгүй байгаагүй. Соёл үүсэн хөгжиж, деградаци буюу доройтолд орж, нэг улс орноос нөгөөд түгэн дэлгэрч, өнгөрсөн үеийнхнээс ирээдүйд дамжигддаг билээ. Соёлын динамик нь орон зайд, цагт соёлын шинж өөрчлөгдөж, шинэчлэгдэхийг илэрхийлдэг юм;
- Зохион бүтээхүй (изобретение) нь соёлын илэрхий мэдэгдэж байгаа элементүүд буюу цогцолборын шинэ зохирол юм. Энэ нь юмыг бэлтгэх шинэ арга буюу технологийг агуулж байдаг. Зохион бүтээхүйд зөвхөн техникийн болон шинжлэх ухааны шинэчлэл төдийгүй бас нийгмийн, жишээ нь төрийн удирдлагын шинэ хэлбэрийг бүтээхийг ойлгодог. Тэдгээрийг материаллаг ба оюуны гэж хувааж үзэж болно;
- Хүний зохион бүтээсэн анхны томоохон зүйл нь саваа мод болон чулууг хамгаалах хэрэгсэл болгон ашигласанд оршино. Удаах нь зэвсгийг хөдөлмөрийн зэвсэг болгосонд, гуравдугаарх нь галыг ашигласан явдал байв. Угсаатан судлаачид, хүн судлаачид түүхэнд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн 200 орчим соёлын тийм (зохион) бүтээлийг ялгаж үзжээ. Тийм бүтээл ба нээлт нь өөр соёлд гурван үндсэн арга буюу
 - зорилго чиглэлтэй дуурайх байдаар соёлыг зээлдэн авах
 - соёлын нэвчилт (ургалаар түгэн дэлгэрэх)
 - үл хамаарах нээлтийн замаар тархдаг байна;

- Нийгэм дэх том цар хэмжээний өөрчлөлтийн ээрэг үр дагаврын нийлбэр хэрэв сөрөг үр дагаварын нийлбэрээс давж байвал дэвшлийн тухай, эсрэг тохиолдолд регресс буюу бууралтын тухай ярих юм. Хүний нийгэм зэрлэг төлөвөөс иргэншлийн орчилд хүрэх даян дэлхийн түүхэн даяар үйл явцыг нийгмийн дэвшил гэж нэрлэдэг. Нийгмийн дэвшлийн алгуур болон үсрэлт маягийн төрлийг ялгаж үздэг. Эхнийх нь реформист, нөгөөх нь хувьсгалт дэвшил болно. Реформ нь оршин буй нийгмийн байгууллын үндсийг хөндөхгүй алгуур өөрчлөлтүүд, амьдаралын аль нэг хүрээн дэх хэсэгчилсэн төгөлдөржүүлэлт юм. Харин хувьсгал нь оршин буй байгууллын үндсийг хөндөх, нийгмийн амьдарлын бүх, эсвэл дийлэнх талыг цогцолбоороор нь өөрчлөхүй болно. Хувьсгал нь үсрэлт шинж чанартай бөгөөд нийгмийн нэгэн чанарын төлөвөөс нөгөө чанарын төлөвт шилжих шилжилт болоно. Түүхэн дэх хамгийн агуу их хувьсгал бол шинэ чулуун зэвсгийн хувьсгал юм. Түүнтэй амьтныг гаршуулах, ургамал тариалан эрхлэх явдлыг харьцуулашгүй юм гэжээ.

Тэрчлэн зохиогч гадаад гаралтай нэлээд хэдэн нэр томъёог энд тайлбарласаныг орхиж үлдээх бодол төрөөгүй бөгөөд харин энэ удаад орчуулгагүй оруулсан болохоо хүлцэн өчье.

"Соёлын лаг" гэдэг нь соёлын нэг хэсэг түргэн, негөө хэсэг удаан өөрчлөгдөх нөхцөл байдлыг илэрхийлэх ба "Соёлын хожимдол" нь түрүүлж байгаа материаллаг соёл (жишээ нь, шинжлэх ухаан техникийн дэвшил)-ын хөгжилд оюуны соёл зохицож амжихгүй байх тийм тохиолдолд гардаг. "Соёлын трансмисси" нь соёлыг өмнөх үеийнхнээс хойч үед сургалтаар дамжуулах үйл явц юм. Энэ нь соёлын уламжлан залгамжлагдах байдал, цаг хугацаанд соёл тасралтгүй байх боломжийг бүрдүүлнэ. Тэгвэл "Соёлын аккумуляци" бол соёлын өв бүрэлдэж дуусгавар болох үйл явц юм.